



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Нэрийн дансны 2012 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хурлын 03 дугаар тэмдэглэлийн шийдвэр, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2012 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 20,6 хувиар баталсугай.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т ДААЛГАХ нь:

а/ Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2012 оны орлогод хүү тооцох арга хэмжээг 2013 оны 3 дугаар улиралд багтаан авч хэрэгжүүлэх;

б/ Нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад хүргэх оновчтой арга хэлбэрийг сонгож, 2013 оны 4 дүгээр улиралд багтаан даатгуулагчдад мэдээлэх хуудас хүргэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын алба (Ц.Алтанцэцэг)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ